



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/655

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын 0102 ХОЕ улсын дугаартай Гранд старекс маркийн автобусаар 2021 оны 07 дугаар сарын 29-31-ний хооронд Улаанбаатар хотоос вакцин татан авалт хийсэн шатахууны зардалд 1 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгийн зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 3323
D/Zah-A/655-Bo